



ВАРРОА ХАЧИГТАЙ ТЭМЦЭХЭД ЧИГЛЭСЭН ТУРШИЛТ СУДАЛГААГ ЭХЛҮҮЛЭВ

Зөгийн голлох өвчнүүдийн нэг болох варроа хачгийн халдвар нь дэлхий нийтэд тулгамдсан асуудал болж байдаг ба Монгол улсад ч мөн адил юм. Өнгөрсөн жилээс хойш төслийн багт олон удаа энэхүү хачгийн улмаас эрсдэлд өртсөн тухай мэдээлэл ирсээр байна.

Иймээс тус төслийн хүрээнд хачгийн занга гэх тэмцэх аргыг Монгол орны нөхцөлд нэвтрүүлэх зорилгоор туршилт судалгааны ажлыг эхлүүлж байна. Энэ арга нь эр зөгий бойжиж буй ташаалавчинд хачиг орж үрждэг байдлыг ашиглаж эр зөгий үржих зориулалттай жаазыг занга болгон тэнд орсон хачгийг устгах явдал юм.

Эмийн бус энэхүү арга нь эмийн зохисгүй хэрэглээнээс сэргийлж буй явдал болно гэж харж байна.

Туршилт судалгааг Мал эмнэлгийн хүрээлэн, Дархан-Уул аймгийн МЭГ, Сэлэнгэ аймгийн МЭГ, зөгийн аж ахуйтай хамтран хэрэгжүүлж байна.



Хачгийн занга (эр зөгийд зориулсан жааз)




Дээж авахад ашиглах зүйлс

МОНМАР-AVC төсөлтэй хамтран малын эмч нарт сургалт зохион байгуулав !

6-р сарын 17,18-ны өдрүүдэд ЖАЙКА байгууллагын хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах төслийн санаачлагаар (MONMAP-AVC) малын эмч нарт зориулсан сургалт зохион байгуулав. Тус сургалтаар өнгөрсөн оны 4-р сард батлагдсан зөгийн аж ахуйд мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх нийтлэг зааврыг хэрхэн мөрдөх тухай танилцуулсан ба BeeDep төслөөс гарсан үр дүнг ашиглав.

Тус сургалтанд 17-ны өдөр Дархан-Уул аймгаас 10, 18-ны өдөр Сэлэнгэ аймгаас 42 малын эмч оролцсон. Оролцогчид маш идэвхитэй байсан ба эмийн үлдэгдэл, импортын зөгийн бүлийн хяналтын тухай зэрэг олон асуултыг ирүүлж байлаа.



Сэлэнгэ аймгийн сургалт. Сургалтын төгсгөлд бүх оролцогч камераа асаан гар өргөх аргаар шалгалтын тэстэд хариулав.

ТОМИЛОЛТЫН МЭДЭЭЛЭЛ



**Төслийн
менежер
НИШИЯАМА
Акиёо**

Би 4-р сарын 13-аас 6-р сарын 25-ны хооронд Улаанбаатарт байсан.

Өнөө жил Монголд хур ихтэй цэцэгс дэлгэрсэн зун болох төлөвтэй ч бал хураалтын улиралын бороо нь ЗАА-д сөргөөр нөлөөлдөг.

Монгол улсад COVID 19-ийн халдвар тархаж байгаа нь ЗАА эрхлэгчдэд сөргөөр нөлөөлж буй буюу өвөлжөөнөөс зөгий гаргах, отор нүүдэл хийх, байгаа, борлуулалт хийхэд төвөг учруулж байна.

Зөгийн өвчинтэй цаг хугацаанд нь тэмцэхэд мөн саад болж болзошгүй юм.

Хачгийн тархалт, эмийн зохисгүй хэрэглээ зэрэг олон асуудал байна.

Гэвч бид МЭХ, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймаг зэрэг талуудтай хамтран ажиллаж илүү их үр дүн гаргахыг зорьж байгаа болно.

Төслийн Facebook :

www.facebook.com/BeeDep-MONGOL-2-107843977265085/?modal=admin_todo_tour

Онлайн семинарыг хүргэж байна !

